ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2022/196/НА-СТА-ТШЗ**

| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өвөрхангай аймаг,<br>Арвайхээр сум<br>2022 он | Тэргүүлэх аудитор: | О.Батжаргал |
| | Утас: 70323253 | Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn |
| | Аудитын менежер: | Д.Гансүх |
| | Утас: 70323833 | Цахим хаяг: gansukh.audit@gmail.com |
| | Аудитор: | Ө.Ринчинмядаг |
| | Утас: 70323108 | Цахим хаяг: rinchinmyadagu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ ..... 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 12
3.Аудитын тайлан ..... 12
3.1 Ерөнхий зүйл ..... 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 13
3.4 Материаллаг байдал ..... 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
3.8 Аудитын гол асуудал ..... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
4. Аудитын илрүүлэлт ..... 15
4.1 Залруулсан алдаа ..... 15
4.2 Төлбөрийн акт ..... 15
4.3 Албан шаардлага ..... 15
4.4 Зөвлөмж ..... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 16

## 1.Аудитын гэрчилгээ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.28 № 84

танай ____________-ны №____________-т

ХАРХОРИН СУМ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТЭС-423
ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ
ХОРИХ АНГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Б.ТҮВШИНТӨГС ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

015030

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 372,587,399.04 | 343,012,868.9 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 14,396,612 | 10,367,316.88 |
| 3 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 14,396,612 | 10,367,316.88 |
| 4 | Төгрөг | 14,396,612 | 10,367,316.88 |
| 5 | Төрийн сангийн харилцах | 14,396,612 | 10,367,316.88 |
| 6 | АВЛАГА | 16,541,999.6 | 15,541,999.6 |
| 7 | Бусад авлага | 16,541,999.6 | 15,541,999.6 |
| 8 | Байгууллагаас авах авлага | 16,541,999.6 | 15,541,999.6 |
| 9 | БАРАА МАТЕРИАЛ | 341,648,787.44 | 317,103,552.42 |
| 10 | Түүхий эд материал | 39,890,432.5 | 43,987,997.5 |
| 11 | Тусгай зориулалттай материал | 34,250,352.5 | 43,085,087.5 |
| 12 | Эм боох материал | 5,640,080 | 902,910 |
| 13 | Дуусаагүй үйлдвэрлэл | 42,289,664.07 | 28,699,212.07 |
| 14 | Бэлэн бүтээгдэхүүн | 61,237,162.53 | 55,397,650.21 |
| 15 | Хангамжийн материал | 153,963,528.34 | 145,900,692.64 |
| 16 | Бичиг хэргийн материал | 1,333,260 | 1,802,600 |
| 17 | Аж ахуйн материал | 54,836,498.54 | 80,987,560.54 |
| 18 | Сэлбэг хэрэгсэл | 3,426,000 | 4,098,600 |
| 19 | Түлш, шатах тослох материал | 22,416,604 | 18,515,517 |
| 20 | Барилгын засварын материал | 8,615,879 | 7,958,720 |
| 21 | Хүнсний материал | 50,360,286.8 | 24,467,375.1 |
| 22 | Бусад хангамжийн материал | 12,975,000 | 8,070,320 |
| 23 | Мал амьтад | 44,268,000 | 43,118,000 |
| 24 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,916,787,950.06 | 1,810,453,974.14 |
| 25 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,916,787,950.06 | 1,810,453,974.14 |
| 26 | Биет хөрөнгө | 1,771,548,206.38 | 1,665,453,974.14 |
| 27 | Барилга, байгууламж, орон сууц | 1,591,965,220.33 | 1,591,965,220.33 |
| 28 | Хуримтлагдсан элэгдэл | -136,456,045.38 | -199,746,143.1 |
| 29 | Авто-тээврийн хэрэгсэл | 156,700,000 | 156,700,000 |
| 30 | Хуримтлагдсан элэгдэл | -130,816,666.93 | -141,700,000.05 |
| 31 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 473,430,106.35 | 419,507,411.77 |
| 32 | Хуримтлагдсан элэгдэл | -252,441,068.27 | -220,470,695.08 |
| 33 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 82,053,352.52 | 63,484,059.12 |
| 34 | Хуримтлагдсан элэгдэл | -46,478,220.88 | -36,716,641.25 |
| 35 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 26,046,548 | 26,046,548 |
| 36 | Бусад үндсэн хөрөнгө | 9,286,130 | 9,286,130 |
| 37 | Хуримтлагдсан элэгдэл | -1,741,149.36 | -2,901,915.6 |
| 38 | Биет бус хөрөнгө | 145,239,743.68 | 145,000,000 |
| 39 | Програм хангамж | 7,646,684.71 | 7,646,684.71 |
| 40 | Хуримтлагдсан элэгдэл | -7,406,941.03 | -7,646,684.71 |
| 41 | Бусад биет бус хөрөнгө | 145,000,000 | 145,000,000 |
| 42 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,289,375,349.1 | 2,153,466,843.04 |
| 43 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 14,396,612 | 4,816,275 |
| 44 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 14,396,612 | 4,816,275 |
| 45 | Өглөг | 14,396,612 | 4,816,275 |
| 46 | Бусад өглөг | 14,396,612 | 4,816,275 |
| 47 | Байгууллагад төлөх өглөг | | 140,000 |
| 48 | Хувь хүмүүст төлөх өглөг | 14,396,612 | 4,676,275 |
| 49 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,274,978,737.1 | 2,148,650,568.04 |
| 50 | Засгийн газрын хувь оролцоо | 2,274,978,737.1 | 2,148,650,568.04 |
| 51 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 341,036,811.2 | 341,036,811.2 |
| 52 | Хуримтлагдсан үр дүн | 753,361,244.18 | 627,033,075.12 |
| 53 | Өмнөх үеийн үр дүн | 819,116,578.27 | 753,361,244.18 |
| 54 | Тайлант үеийн үр дүн | -65,755,334.09 | -126,328,169.06 |
| 55 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,180,580,681.72 | 1,180,580,681.72 |
| 56 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,289,375,349.1 | 2,153,466,843.04 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,034,766,070.9 | 1,767,404,575 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 540,023,670.9 | 279,166,295 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 534,140,670.9 | 264,752,145 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 469,593,069 | 217,176,600 |
| 5 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 209,884,019 | |
| 6 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 205,753,400 | 217,176,600 |
| 7 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 53,955,650 | |
| 8 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 11,440,000 | 5,704,000 |
| 9 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 53,107,601.9 | 56,285,695.00 |
| 10 | Тусламжийн орлого | 5,883,000 | - |
| 11 | Хандив тусламж /дотоод/ | 5,883,000 | - |
| 12 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,494,742,400 | 1,488,238,280 |
| 13 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,493,192,400 | 1,467,244,800 |
| 14 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,493,192,400 | 1,467,244,800 |
| 15 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,550,000 | 20,993,480 |
| 16 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,550,000 | 20,000,000 |
| 17 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 993,480 |
| 18 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,100,521,404.99 | 1,893,292,742.06 |
| 19 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,100,521,404.99 | 1,893,292,742.06 |
| 20 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,010,142,106.7 | 1,808,456,442.76 |
| 21 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,035,005,950.36 | 1,016,314,258.12 |
| 22 | Үндсэн цалин | 710,229,682.58 | 651,670,158.12 |
| 23 | Нэмэгдэл | 324,776,267.78 | 364,644,100 |
| 24 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,197,851.35 | 23,280,299.93 |
| 25 | Тэтгэврийн даатгал | 2,160,740.24 | |
| 26 | Тэтгэмжийн даатгал | 254,204.74 | |
| 27 | ҮОМШӨ-ний даатгал | 203,363.77 | |
| 28 | Ажилгүйдлийн даатгал | 23,135.64 | |
| 29 | Эрүүл мэндийн даатгал | 20,556,406.96 | 23,280,299.93 |
| 30 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 145,924,429.15 | 135,933,991.95 |
| 31 | Гэрэл, цахилгаан | 85,573,500 | 80,274,060 |
| 32 | Түлш, халаалт | 54,500,929.15 | 49,817,291.95 |
| 33 | Цэвэр, бохир ус | 5,850,000 | 5,842,640 |
| 34 | Хангамж, бараа материалын зардал | 56,171,320.84 | 88,226,580.05 |
| 35 | Бичиг хэрэг | 3,865,340 | 5,973,960 |
| 36 | Тээвэр, шатахуун | 27,358,340 | 31,115,431.05 |
| 37 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,114,310 | 2,298,143 |
| 38 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 197,000 | 197,000 |
| 39 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 59,720 |

| | | | |
|---|---|---|---|
| 40 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,521,479.84 | 46,477,326 |
| 41 | Бараа материал акталсны зардал | 14,114,851 | 2,105,000 |
| 42 | Нормативт зардал | 360,804,374.47 | 289,849,254.02 |
| 43 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,592,513 | 18,025,870 |
| 44 | Хоол, хүнс | 324,186,592.27 | 259,163,581.7 |
| 45 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 25,025,269.2 | 12,659,802.32 |
| 46 | Эд хогшил, урсгал засварын зардал | 58,884,894.25 | 46,151,199 |
| 47 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 402,400 |
| 48 | Урсгал засвар | 58,884,894.25 | 45,748,799 |
| 49 | Томилолт, зочны зардал | 287,200 | |
| 50 | Дотоод албан томилолт | 287,200 | |
| 51 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 176,045,009 | 56,721,596 |
| 52 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 170,344,690 | 50,515,157 |
| 53 | Тээврийн хэрэгслийн татвар | 434,900 | 419,853 |
| 54 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000 | 165,000 |
| 55 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,135,300 | 1,275,000 |
| 56 | Газрын төлбөр | 3,954,119 | 4,346,586 |
| 57 | Бараа үйлчилгээний бусад зардал | 153,821,077.28 | 151,979,263.69 |
| 58 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,822,527 | 18,811,928 |
| 59 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 249,900 | 260,400 |
| 60 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 143,748,650.28 | 132,906,935.69 |
| 61 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 90,379,298.29 | 84,836,299.3 |
| 62 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 32,617,200 | 25,207,200 |
| 63 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 32,617,200 | 25,207,200 |
| 64 | Бусад урсгал шилжүүлэг | 3,200,700 | 11,620,600 |
| 65 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,200,700 | 11,620,600 |
| 66 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 98.29 | 8,008,499.3 |
| 67 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 98.29 | 8,008,499.3 |
| 68 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 54,561,300 | 40,000,000 |
| 69 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,561,300 | 40,000,000 |
| 70 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -65,755,334.09 | -125,888,167.06 |
| 71 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 440,002 |
| 72 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 2 |
| 73 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 440,000 |
| 74 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -65,755,334.09 | -126,328,169.06 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,056,357,253.49 | 1,856,137,352.31 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 561,614,853.49 | 367,899,072.31 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 561,614,853.49 | 367,899,072.31 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 561,614,853.49 | 353,220,030.43 |
| 5 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 209,884,019 | 142,150,100 |
| 6 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 351,730,834.49 | 211,069,930.43 |
| 7 | Бусад орлого | | 14,679,041.88 |
| 8 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,494,742,400 | 1,488,238,280 |
| 9 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,493,192,400 | 1,467,244,800 |
| 10 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,493,192,400 | 1,467,244,800 |
| 11 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,550,000 | 20,993,480 |
| 12 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,550,000 | 20,000,000 |
| 13 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 993,480 |
| 14 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,061,158,451.25 | 1,839,297,685.66 |
| 15 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,061,158,451.25 | 1,839,297,685.66 |
| 16 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,970,779,152.96 | 1,755,361,386.36 |
| 17 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,035,005,901.71 | 1,030,853,300 |
| 18 | Үндсэн цалин | 656,936,800 | 666,209,200 |
| 19 | Нэмэгдэл | 377,069,101.71 | 364,644,100 |
| 20 | Урамшуулал | 1,000,000 | |
| 21 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,197,900 | 23,280,299.93 |
| 22 | Эрүүл мэндийн даатгал | 23,197,900 | 23,280,299.93 |
| 23 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 150,293,500 | 139,922,900 |
| 24 | Гэрэл, цахилгаан | 85,573,500 | 80,151,500 |
| 25 | Түлш, халаалт | 58,870,000 | 53,785,400 |
| 26 | Цэвэр, бохир ус | 5,850,000 | 5,986,000 |
| 27 | Хангамж, бараа материалын зардал | 44,509,100 | 40,874,280 |
| 28 | Бичиг хэрэг | 2,908,000 | 2,787,000 |
| 29 | Тээвэр, шатахуун | 38,328,100 | 34,644,480 |
| 30 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,168,300 | 2,219,200 |
| 31 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 197,000 | 197,000 |
| 32 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 907,700 | 1,026,600 |
| 33 | Нормативт зардал | 294,651,800 | 212,053,000 |
| 34 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,053,200 | 6,493,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 35 | Хоол, хүнс | 281,598,600 | 205,560,000 |
| 36 | Эд хогшил, урсгал засварын зардал | 81,647,400 | 84,804,600 |
| 37 | Багаж, техник, хэрэгсэл | 10,691,000 | 29,570,500 |
| 38 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,910,000 | 1,811,800 |
| 39 | Урсгал засвар | 63,046,400 | 53,422,300 |
| 40 | Томилолт, зочны зардал | 287,200 | |
| 41 | Дотоод албан томилолт | 287,200 | |
| 42 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 320,325,451.25 | 202,103,706.43 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 314,485,432.25 | 195,897,267.43 |
| 44 | Тээврийн хэрэгслийн татвар | 434,900 | 419,853 |
| 45 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000 | 165,000 |
| 46 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,275,000 | 1,275,000 |
| 47 | Газрын төлбөр | 3,954,119 | 4,346,586 |
| 48 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,860,900 | 21,469,300 |
| 49 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,303,500 | 20,986,200 |
| 50 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 557,400 | 483,100 |
| 51 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 90,379,298.29 | 83,936,299.3 |
| 52 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 32,617,200 | 25,207,200 |
| 53 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 32,617,200 | 25,207,200 |
| 54 | Бусад урсгал шилжүүлэг | 3,200,700 | 10,720,600 |
| 55 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,200,700 | 10,720,600 |
| 56 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 98.29 | 8,008,499.3 |
| 57 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 98.29 | 8,008,499.3 |
| 58 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 54,561,300 | 40,000,000 |
| 59 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,561,300 | 40,000,000 |
| 60 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | -4,801,197.76 | 16,839,666.65 |
| 61 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 858,000 | 20,868,961.77 |
| 62 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 858,000 | 20,868,961.77 |
| 63 | Дотоод эх үүсвэрээр | 858,000 | 20,868,961.77 |
| 64 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 858,000 | 20,868,961.77 |
| 65 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -858,000 | -20,868,961.77 |
| 66 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -5,659,197.76 | -4,029,295.12 |
| 67 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 20,055,809.76 | 14,396,612 |
| 68 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 14,396,612 | 10,367,316.88 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 819,116,578.27 | 2,340,734,071.19 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 819,116,578.27 | 2,340,734,071.19 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | -65,755,334.09 | -65,755,334.09 |
| 4 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 753,361,244.18 | 2,274,978,737.1 |
| 5 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 753,361,244.18 | 2,274,978,737.1 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 753,361,244.18 | 2,274,978,737.1 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | -126,328,169.06 | -126,328,169.06 |
| 8 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 341,036,811.2 | 1,180,580,681.72 | 627,033,075.12 | 2,148,650,568.04 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| № | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,704,171,200 | 1,704,171,020.71 | 1,609,394,900 | 1,601,386,400.70 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,704,171,200 | 1,704,171,020.71 | 1,609,394,900 | 1,601,386,400.70 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,668,353,300 | 1,668,353,120.71 | 1,574,477,800 | 1,574,446,600.70 |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,035,006,000 | 1,035,005,901.71 | 1,030,853,300 | 1,030,853,300 |
| 5 | Үндсэн цалин | 656,936,800 | 656,936,800 | 662,609,200 | 666,209,200 |
| 6 | Нэмэгдэл | 377,069,200 | 377,069,101.71 | 364,644,100 | 364,644,100 |
| 7 | Урамшуулал | 1,000,000 | 1,000,000 | 3,600,000 | |
| 8 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,197,900 | 23,197,900 | 23,280,300 | 23,280,299.93 |
| 9 | Эрүүл мэндийн даатгал | 23,197,900 | 23,197,900 | 23,280,300 | 23,280,299.93 |
| 10 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 150,293,500 | 150,293,500 | 139,922,900 | 139,922,900 |
| 11 | Гэрэл, цахилгаан | 85,573,500 | 85,573,500 | 80,151,500 | 80,151,500 |
| 12 | Түлш, халаалт | 58,870,000 | 58,870,000 | 53,785,400 | 53,785,400 |
| 13 | Цэвэр, бохир ус | 5,850,000 | 5,850,000 | 5,986,000 | 5,986,000 |
| 14 | Хангамж, бараа материалын зардал | 44,509,100 | 44,509,100 | 39,880,800 | 39,880,800 |
| 15 | Бичиг хэрэг | 2,908,000 | 2,908,000 | 2,787,000 | 2,787,000 |
| 16 | Тээвэр, шатахуун | 38,328,100 | 38,328,100 | 33,651,000 | 33,651,000 |
| 17 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,168,300 | 2,168,300 | 2,219,200 | 2,219,200 |
| 18 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 197,000 | 197,000 | 197,000 | 197,000 |
| 19 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 907,700 | 907,700 | 1,026,600 | 1,026,600 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | Нормативт зардал | 294,651,800 | 294,651,800 | 212,053,000 | 212,053,000 |
| 21 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,053,200 | 13,053,200 | 6,493,000 | 6,493,000 |
| 22 | Хоол, хүнс | 281,598,600 | 281,598,600 | 205,560,000 | 205,560,000 |
| 23 | Эд хогшил, урсгал засварын зардал | 80,955,400 | 80,955,400 | 85,673,600 | 85,673,561.77 |
| 24 | Багаж, техник, хэрэгсэл | 9,999,000 | 9,999,000 | 30,439,500 | 30,439,461.77 |
| 25 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,910,000 | 7,910,000 | 1,811,800 | 1,811,800 |
| 26 | Урсгал засвар | 63,046,400 | 63,046,400 | 53,422,300 | 53,422,300 |
| 27 | Томилолт, зочны зардал | 287,200 | 287,200 | 31,100 | |
| 28 | Дотоод албан томилолт | 287,200 | 287,200 | 31,100 | |
| 29 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,591,500 | 18,591,419 | 21,313,500 | 21,313,439 |
| 30 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,751,400 | 12,751,400 | 15,107,000 | 15,107,000 |
| 31 | Тээврийн хэрэгслийн татвар | 434,900 | 434,900 | 419,900 | 419,853 |
| 32 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000 | 176,000 | 165,000 | 165,000 |
| 33 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,275,000 | 1,275,000 | 1,275,000 | 1,275,000 |
| 34 | Газрын төлбөр | 3,954,200 | 3,954,119 | 4,346,600 | 4,346,586 |
| 35 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,860,900 | 20,860,900 | 21,469,300 | 21,469,300 |
| 36 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,303,500 | 20,303,500 | 20,986,200 | 20,986,200 |
| 37 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 557,400 | 557,400 | 483,100 | 483,100 |
| 38 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,817,900 | 35,817,900 | 34,917,100 | 26,939,800 |
| 39 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 32,617,200 | 32,617,200 | 33,184,500 | 25,207,200 |
| 40 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 32,617,200 | 32,617,200 | 33,184,500 | 25,207,200 |
| 41 | Бусад урсгал шилжүүлэг | 3,200,700 | 3,200,700 | 1,732,600 | 1,732,600 |
| 42 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,200,700 | 3,200,700 | 1,732,600 | 1,732,600 |
| 43 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,704,171,200 | 1,704,171,020.71 | 1,609,394,900 | 1,609,394,900 |
| 44 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,493,192,400 | 1,493,192,301.71 | 1,467,244,800 | 1,467,244,800 |
| 45 | Улсын төсвөөс санхүүжих | 1,493,192,400 | 1,493,192,301.71 | 1,467,244,800 | 1,467,244,800 |
| 46 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 210,978,800 | 210,978,719 | 142,150,100 | 142,150,100 |
| 47 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 209,884,100 | 209,884,019 | 142,150,100 | 142,150,100 |
| 48 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,094,700 | 1,094,700 | | |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1550000.00** | **20993480.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1550000.00** | **20993480.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1550000.00 | 20993480.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 993480.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 993480.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1550000.00 | 20000000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1550000.00 | 20000000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1550000.00 | 20993480.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1550000.00 | 20993480.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1550000.00 | 20000000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 993480.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 14396612.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 10367316.88 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.26-ны өдрийн 01/80 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ашиглалтыг эрчимжүүлэх. Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх. Шударга ёс, ил тод байдлыг хангаж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүндрэлгүй зохион

байгуулах. Нийт бие бүрэлдэхүүний цэрэгжилт, албаны бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн "Эрх бүхий албан тушаалтны жагсаалт батлах тухай" А/04 дүгээр тушаалаар тус ангийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, дэд хурандаа Б.Эрхэмбаяр тус ангийн дотоод хяналт шалгалт, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх эрх бүхий албан тушаалтнаар томилогдсон.

Ангийн даргаар 2021 онд дотоод хяналт шалгалтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт бус албаны шалгалт нийт 11 удаа хийж зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Сахилга ёс зүйн зөрчил гаргасан 10 алба хаагчид ангийн даргын, 1 алба хаагчид ШШГЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1,767.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нэмэлт санхүүжилтээр 20 сая төгрөгөөр уурын зуухны төхөөрөмжүүдийг шинэчлэн машин тоног төхөөрөмжид бүртгэсэн. Мөн 5.7 сая төгрөгийн 2 тоног төхөөрөмж шилжиж ирсэн.

Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан үзэхэд аж ахуйн материалын үлдэгдэл 26.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, хүнсний материал 25.8 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 1,467.24 сая төгрөгийг улсын төсвөөс, 142.15 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 5.9 хувиар буурсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 1,601.4 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1,601.4 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 20.993 сая төгрөгийг тээвэр, шатахуун; багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардалд тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд төсөвт тусгалгүйгээр ахмадын санд цалингийн хэмнэлтийг төвлөрүүлсэн зөрчил илэрсэн. Мөн дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг олон нийтэд мэдээлсэн боловч 14 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллын 2020 оны санхүүгийн тайланд Шилэн дансны хуулийн хэрэгжилт холбоотойгоор 467.01 сая төгрөгийн албан шаардлага; харилцагч байгууллагын гэрээг дүгнээгүй, гүйцэтгэлийг бүрэн баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн. Зөрчлийг арилгаж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.26 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.58 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Ахмадын сан байгуулахдаа шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж батлуулаагүй. Цалингийн хэмнэлтийг ахмадын санд төвлөрүүлсэн байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Анхан шатны баримттай холбоотой асуудал***

1.1 *Илрүүлэлт:*

*Жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө спидометрийн заалтыг бүрэн хөтөлдөггүй, анхан шатны баримтын хөтлөлт дутуу хийгдсэн байна.*

1.2 *Өгсөн зөвлөмж:*

*Анхан шатны баримтын хөтлөлтийг журмын дагуу хийх, дотоод хяналтыг сайжруулах.*

2. ***Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

2.1 *Илрүүлэлт:*

*Шилэн дансны цахим хуудаст нийт 14 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан; 1,680.0 мянган төгрөгийн 7 хөрөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй байна.*

2.2 *Өгсөн зөвлөмж:*

*Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн байршуулах, дотоод хяналтыг сайжруулах*

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | 3 | 16.256 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 14.576 | 2 | 1.68 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДӨР